

# “ГЛОБАЛ МОНГОЛИА ХОЛДИНГС” ХК ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ШИЙДВЭР

2023 оны 10 дугаар  
сарын 07-ны өдөр

№ 23-01

Улаанбаатар  
хот

## Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал зарлах тухай

Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйл, 61 дүгээр зүйлийн 61.1.1, 61.1.2 дахь заалт, 61.7 дахь хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.1, 62.1.7 дахь заалт, 65 дугаар зүйлийн 65.3, 65.4 дэх заалт, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 12 сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”, “Глобал Монголиа Холдингс”ХК-ын холбогдох хэсгийг тус тус үндэслэн **ШИЙДВЭРЛЭХ** нь:

1. “Глобал Монголиа Холдингс” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурал (цаашид “Хурал” гэх)-ыг 2023 оны 11 дүгээр сарын 17 -ны өдрийн 10:00 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сонор плаза 602-д танхимаар, цахимаар зарлан хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлах тухай мэдэгдлийг 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор Монголын Хөрөнгийн Бирж, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжинй төв, Санхүүгийн Зохицуулах Хороо болон холбогдох бусад этгээдэд тус тус хүргүүлсүгэй.
3. Хурал хуралдуулах тухай зар мэдээг Монголын Хөрөнгийн Биржийн цахим хуудас, өдөр тутмын хоёроос доошгүй сонин болон бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан 2023 оны 10 дугаар сарын 12-ний өдрийн дотор нийтэд мэдээлж, уг зарын давталтыг 2023 оны 10 сарын 27-ний өдөр анх зарласан хэлбэрээр дахин нийтэд мэдээлсүгэй.
4. Хуралд оролцох эрхтэй Хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2023 оны 11 дүгээр сарын 3-ны өдрөөр тогтоосугай.
5. Хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт, гарах шийдвэрийн төсөл, танилцуулга саналын хуудас зэрэг бусад холбоотой баримт бичгийг 2023 оны 10 сарын 17-ны өдөрт багтаан үнэт цаасны брокер, дилерийн компанид хүргүүлсүгэй.
6. Хурал зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд
  - 6.1.Хурал зохион байгуулах комиссын дарга:
    - Хан Гю Бун
  - 6.2.Хурал зохион байгуулах комиссын гишүүд:
    - Г.Энхзул
7. Хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг Хавсралт 1-ийн дагуу, хурлын нийтэд хүргэх зарыг Хавсралт 2-ын дагуу, хувьцаа эзэмшигчдээс санал авах хуудсыг Хавсралт 3-ын дагуу, хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийн жагсаалтыг Хавсралт 4-ийн дагуу, хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаас гарах тогтоолын төслийг Хавсралт 5-ын дагуу тус тус баталсугай.
8. Хувьцаа эзэмшигчдийн санал хүлээн авах эцсийн хугацааг 2023 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 10:00 цаг байхаар тогтоосугай.

9. Хурлын даргаар Глобал Монголиа Холдингс ХК-ийн Хан Гю Бун-г томилсугай.
10. Хурлын тооллогын комиссоор М.Лхамсүрэн-г ажиллуулахыг зөвшөөрсүгэй.
11. Энэхүү шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж, холбогдох мэдээлэл, баримт бичгийг хүргүүлэх, бүртгүүлэх ажлыг хийж гүйцэтгэхийг Хан Гю Бун-д даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ:



ПАК ЧАН СУ